

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсан	Дугаар	L153
Оршин суугаа аймаг	Баянхонгор	Оршин суугаа сум	Эрдэнэцогт
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дайчин вангийн хүрээ, Даяаны хийд	Сүм хийдийн дугаар	БХЭЦ 093, БХЭЦ 084
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Дайчин вангийн хүрээ, Даяаны хийд

Асуулт:-Лувсан гуай бид нарт тус сумын нутагт байсан Дайчин вангийн хүрээний тухай асууж лавлалаа, та бидэнд ярьж өгнө үү?

Хариулт:-Манай Дайчин ван бол 2 хүрээтэй байсан юм. Нэг хүрээ нь одоогийн энэ Эрдэнэцогтод байгаа **Ханчай хонгорзонгийн** хийд байгаа юм. Нэг хүрээ нь бол дээхнэ голынхоо хойд талд Өлзийтийн аман дээр байсан юм. Тэр нь **Даяа** гэж нэрлэж байсан юм. Тэрнийг тэргүүлж байсан лам нь хувилгаан багш гэж нэрлэж байсан юм. Тийм хутагт байсан юм. Хувилгаан багшийг урд шавиа Баянзүрхээс залсан юм, 3 настайд нь. Тэгээд манайх ширээний лам хийгээд Даяан дээрээ суулгасан юм. Энэ хийдийнх Гачин лам толгойлж байсан юм. Ингээд хоёр хийддээ хоёр хутагттай байсан юм.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Манай Даяаны хийд юутай байсан юм бэ гэхээр ямар ч байсан 5 дацантай байсан. 5 дугантай байсан юм байна. Цогчэн дуган, Зуугийн дуган гэж байсан, Мамба дуган гэж байсан, ийм дуганууд байсан юм.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-Эндхийнх цөөхөн гэхдээ 500-гаад лам байсан байхаа. Тэр хийдийн чинь хурал нь Чойр байхгүй. Манай хийд дээр бол **Чойртой** байсан. Дээр **Чойр** байгаагүй. Чойрын оронд **Манба, Дүйнхор** тийм хурлууд хурж байсан юм.

Асуулт:-Аль их игчаагаар **чойр**ын номоо үздэг байсан юм бол?

Хариулт:-Сэрийн **чойртой** байсан, сэрийн **чойр** л гэж ярьж байсан юм.

Асуулт:-Хийдийн барилгыг юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Түрүүчийнх нь дандаа мод байсан, сүүлийн 2, 3 дуган манай эндхийн 3 дуган туйпуу байсан.

Асуулт:-Туйпуугаа хаана яаж бэлддэг байсан юм бол?

Хариулт:-Урд голын хойд тал хоёрын уулзвар дээр хоёр бааюу байсан, **тэрэн** дээр түүхий туйпуу цохиод, тэгээд шатаадаг байсан юм.

Асуулт:-Монголчууд хийх үү?

Хариулт:-Монголчууд өөрсдөө. Чойр дуган, Зуугийн дуган, Энхийн дуган энэ гурав дөрвөлжин оройтой, одоогийн сүмийнх шиг оройтой, тийм дуганууд байсан юм. Тэр гурвуулаа туйпуун дуган байсан юм. Дандаа монголчууд барьж байсан. Тэрнээс урагш дуганууд нь дандаа модон дуганууд байсан.

Асуулт:-Багцаагаар хэд орчим оны үед энэ дуган нээгдсэн юм бол?

Хариулт:-Мэдэхгүй. Хамгийн түрүүчийнхийг мэдэхгүй, намайг мэдэхийн л тийм дуганууд байсан. Сүүлийн Чойр дуган бол 21, 22 оны үед л байсан байх. Өвөрхангай аймгийн Цагаан эргийн аманд байж байгаад нүүгээд явсан хойно тэндээс туйпуу, цемент, хатаад чулуу болсон цементүүдийг авчраад хүүхдүүдээр нүдүүлж шавж байсан юм даа. Нэлээн сүүлд барьсан дуган байгаа юм, тэр Чойр дуганыг бол.

Асуулт:-Энэ хийдийн лам нар ямар уул овоогоо тахидаг байсан юм бол?

Хариулт:-Ямар ч гэсэн манай энэ хийд бол 3 газар тахидаг юм. **Лацын** овоо гэж энд нэг овоо байсан юм, дөрвөлжин суварга, нэлээн өндөр, тэгээд дээрээ баахан мод гозойлгосон. Энэ **суваргануудын** доод хамгийн үзүүрт байсан юм даг, тийм овоо байсан. Түйн голын зүүн уулаа тахидаг байсан юм, **Хөхөө** бүрдээсэн гэж одоо Баянголын төв байгаа энэ Хөх бүрдийн. Энэ гурав тахилгатай байсан.

Асуулт:-Ямархуу маягаар тахидаг байсан юм бол, цагаан идээгээр тахиж байсан уу?

Хариулт:-Цагаан идээгээр тахидаг байсан, шүүс гардаггүй. Дан цагаан идээгээр.

Асуулт:-Хэдэн сард тахидаг байсан юм бол?

Хариулт:-Төдий өдийд гэх юм байхгүй, тахидаг л байсан, жилд нэг удаа л тахидаг байсан. Тогтоод байсан юмгүй. Тэр дор **Гөвшийн** маягийг бас тахидаг байсан. Тэрнээс ч заримдаа тэнд очиж тахидаг, заримдаа энэ урд уулан дээр гараад эндээс толь яаж байгаад тахидаг л байсан даг. Энэ жил хүртэл **Гөвшийн** тэрнийг тахилаа гэж манай энд лам явж байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Баацагааны Жаргалантын овоог бас тахидаг байсан юм. Тэрнийг чухам юугаар тахиж байсан юм мэдэхгүй, шүүс гарч байсан юмуу үгүй юмуу, манай эд нарыг бол шүүс хэрэглэдэггүй байсан, цагаан идээ тавиад тэгээд хошуугаа тойрч эргээд 108 **Ганжуураа** тэмээнд ачаад хувин тэгнээд явдаг байсан. Ганжуураа тойроод тэр хувиндаа амьтан, **жандагууд**, өрөм зөөхий элдэв юмаа халбагадаад хувиндаа хийгээд зулын тос хийдэг байсан. Тэнд хөөрхөн жаахан наадам болбол болно. Бөх ч гэх юм байгаагүй л дээ, тэр үед нэг их олон бөх байгаагүй. Азарга л уралддаг байсан, өөр морь уралддаггүй байсан. Бөх барилддаг байсан юм.

Асуулт:-Майдарын хурлын талаар яриач, доод хүрээ бол **Майдар** эргэдэг бас өвөрмөц болдог байсан, хүмүүс их үздэг байсан гэж ярьдаг шүү дээ.

Хариулт:-Тийм. **Бангийн Майдар** гайхаж байсан юм шүү дээ, ар талын хийд дээр аймаг, хошууд. Үнэхээр сайхан **Майдар** болж байсан юм гэнэ лээ. Манай **Майдар** бол зуныхаа сарын битүүнд эргэдэг байсан. 29-нд нь бол сор залдаг байсан. **Дамдинчойжилын**. 7 хоног 10 ташууд **хувьчихаад**, тэгээд сүүлд нь 29-ндөө Чойжилын сор юм даа, тэгээд залдаг. Мөн **чантай** байсан. Тэгээд битүүнд **Майдараа** эргэдэг байсан. Майдарыг Зуугийн дугандаа залдаг байсан. Үүр шөнө хагацахын тэнд л **нянсан** хийгээд л бүрээ бишгүүр тачигнаад л тэгээд **Майдар** гадаалдаг. Тэгээд урд талын Цогчэн **дуганын** урд том зай байсан юм. Тэндээ залж ирдэг. Майдарыг одооныхтой адилхан машин тэрэг байх биш дээ, дөрвөн дугуйтай улаан тэрэг, төмөр хүрдтэй. **Тэрэн** дээрээ хөөрхөн юу засаад тэгээд торгоор бүрчихсэн жаазтай, **тэрэн** дээрээ **Майдараа** залаад. Ногоон морьтой, Манай **Майдар** бол алтадсан хөөрхөн байдаг байсан юм. Тэгээд сүүлд нь манай Доржжанцан гуай гээд лам байдаг байсан. Ганданд өгсөн. Одоо ганданд байдаг л юм гэнэ лээ. Аль дуганд нь байдаг юм.

Асуулт:-Гандантэгчилэн хийдийн номын санд байдаг юм.

Хариулт:-Сүүлд нь манайхан авах гэсэн өгөөгүй л юм гэнэ лээ.

Асуулт:-Майдарынхаа багийг өөрсдөө хийдэг байсан уу?

Хариулт:-Өөрсдөө л голдуу даа. Манай **Майдар** бол 100 шахуу цамтай байсан. 2 хохь байдаг, 2 азар байдаг, 32 **бэгзтэй**, 21 дарь эхтэй, **Дамдинчойжил**, Чойжил, **Заминд**, Гомбо, Лхам байсан, цаашлаад зөндөө багийн цамууд байсан. Ингээд нийлээд байсаар байгаад нэлээн олон цамтай байсан юм даа. Тэрний хажуугаар зочдоо 16 бага шиг хүүхдүүд цай, тахил юм даа. Жижиг жижиг тахилын юмнуудтай байсан. 8 дудрай. Тэр нь харайлттай тийм байсан юм. 2 арслантай. 2 арслан нь **Майдар** гадаалахаар гарч ирж тойрч жаахан давхиж байгаад орчихдог. Тэгээд **Майдараа** хөдлөөд явахаар зэрэг дагаад явдаг, тэгээд урагш нь гаргаж **өгчихөөд** буцаж ирээд тэгээд улсууд нь хувцсаа тайлчихдаг. Нэг арсланд 2 хүн ордог, нэлээн том бяртай чадалтай улсууд ордог. Баг нь ч том, хойд талын хүн бол нуруу сайтай өндөр хүн ордог, тэр нь дандаа **урдахийнхаа** бүснээс бариад тонгойчихдог. Тэгээд **урдахь** нь **багнаасаа** бариад явж байдаг. Харахад л яг л арслан. Тэгээд багууд бол урагшаа **онгорхойгоороо** гараад хүрээгээ тойроод гол юмаараа, баруун үүдэн дээр очоод үдэлдэг. **Тэрэн** дээр очоод цамууд нь тахил харайж цамнана. Цамууд бас зарим нь харайна. Ямар ч байсан 3 цаг болж байсан байхаа, нэг үд дээр. Тэгээд хойшоо баруун үүд хөдлөөд хойд талд гараад хойд үд болно. Бас тэнд үдэлдэг. Бас тэнд тахил **хуралнууд** хурна. Тэгээд сүүлд нь оройхон шиг зүүн үд гарна. Зүүн талд гарна, хүрээнийхээ зүүн талд. Тэгээд

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

тэнд бас хоёр гурван цаг болоод оройхон ч болно. Тэгээд л орой **Майдар** дотогшоо ирэх болно доо, нар жаргахын үед. Тэгээд хоёр арслан чинь урдаас нь угтаж **Майдараа** очиж авдаг. Тэгээд орж ирдэг, тэгээд **Майдараа** оруулаад дотор залдаг байсан юм даа.

Асуулт:-Ном судраа **барладаг** бар байсан юм болов уу?

Хариулт:-Нэртэй том бар байгаагүй. Жижиг жижиг **барнууд** байсан юм даг, бараг шатаад, устгаад өнгөрсөн л дөө. Сүүлд нь туйпууны чинь **баюунууд** чинь бүх бурхан ном, хамаг юмаа шатаадаг зуух болсон байна лээ. Тэгээд зүйл дуусгасан даа. Тэгээд цамын хувцсыг дандаа мөнгөтэй ч хүн, дандаа үнэтэй торго, хоргой тийм л хувцаснууд байсан даа, бүгд байхгүй, шатаасан.

Асуулт:-Тэр үеийн лам нарын өмсөж байсан дээл?

Хариулт:-**Дээлнээс** гадна цамын хувцас гэж янзын байсан шүү дээ. Нэг **зовуунууд** бол 2, 3 хувцастай. Янз янзын гоё хувцастай. Сүүлдээ **жандаг** ихтэй болоод амьтан чинь янз янзын сонин хувцас хийж өргөдөг байлаа. Тэр **багнууд** чинь тойроод дандаа **юунууд** нь дандаа мөнгө. Мөнгөн **хохийн** толгойнуудтай тийм байсан юм. Тэгээд устгах нь устаад тэр үед шунахайхан хувааж байсан, дээрэмдэж байсан улсууд авч байсан байлгүй тэр мөнгийг бол.

Асуулт:-Таныг бага байхад хийдэд шавилж байгаа хүүхдүүд яаж ном үзэж байсан бэ?

Хариулт:-Хуучин үсгийнхээ багшид шавь ороод тэгээд наад номоо үздэг байгаа. Тэгж байгаад ямар ч байсан хичээл үзээд **Дарь** эх уншаад, үзээд цээжлээд ирэхээр Цогчэндоо ордог байсан юм. Тэгээд Цогчэнд 3 жил хураад тэгээд Чойрт орох гэдэг нь Чойрт орно доо. Чойр 3 жил болоод зиндаа ахидаг байсан юм. Сүүлийн үед бол ерөөсөө манай зиндаа бол хамгийн доод зиндаа байж байсан. Биднээс хойш ерөөсөө хүүхэд оруулаагүй. Чойрт оруулдаггүй. Хориод. Нэмж дээрээс нь заримыг нь гаргах гээд. Ингэдэг байсан юм. Манайхан 5 жил дамжаад гарч байсан доод зиндаа байж байгаад тэгээд хүрээ тарсан. Хамгийн жижиг хүүхдүүд нь миний үе байхад бид нар байсан юм. 40 гаруй улсууд байсан. Тэгээд хүрээ тарсан юм даа. Ном үзэж гийгүүлсэн юм байхгүй бид нар чинь. Хадгийн зиндаа, **шидэвийн** зиндаа гээд доод хоёр зиндаа байсан. дүйра гээд явдаг байсан л даа.

Асуулт:-Ганжуур, **Данжуур** байсан уу?

Хариулт:-Байсан. Байлгүй **яхав**. Хүрээнд нэг л байсан байхаа, олон байгаагүй. Нэг **Ганжуур**, нэг **Данжууртай** байсан байх.

Асуулт:-37 оны үед том том лам нарыг барьж байсан уу?

Хариулт:-Тэгэлгүй **яхав**, гэгээн хутагтаас өгсүүлээд жаахан томхон лам **наруудыг** барьсан. Нэг хэсэг бариад овоо гайгүй болсон чинь сүүлдээ хэдэн он байлаа, нэг жил дотор бараг 100-г барьсан даа.

Асуулт:-Та баригдсан, хэлмэгдсэн том лам нарын нэр усыг мэдэж байна уу?

Хариулт:-Тэр чинь тойм байхгүй. Хэлмэгдсэн нь цагаан номон дээр байгаа. Хэлмэгдсэн улсуудын овог нэр нь байгаа.

Асуулт:-Лам нарыг бариад явсны дараагаар хүрээ хийдүүд ном, судрыг нь яасан бол?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-**Бааюундаа авчаад** түлэхийг нь түлээд, дуганыг чинь нураагаад шатаахыг нь шатаагаад. Манай энэ дуганы энүүхэн талд сүүний зоорь гэж нэг юм бариад, тэрнийг чинь өвөл газрыг нь ухуулаад тэгээд гэсгээхийн тулд дуганыг чинь буулгаж ирж шатаагаад. Газрыг нь гэсгээх гэж. Ялангуяа Цогчэн дуган бол их модтой том дуган байсан.

Асуулт:-Энэ хийдэд **зод, лүйжин** тавьдаг тийм лам нар байсан үү?

Хариулт:-Манай энд тийм хүн байгаагүй. Дээд хийд дээр хэд хэдэн **дацангууд** байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Ламын өргөө яаж үлдсэн юм бол?

**Хариулт:**-Энэ чинь бас л түүх юм байлгүй дээ. Лам нар **ирчихээд** орон сууцгүй, гэр барьж өгсөн, майханд байсан юмуу. Манай ноён Ховд, Завханд амбан байсан юм гэнэ лээ. Вангийн ноён гэж. Тэрэнд энэ лам ирлээ, Түвдээс манайд суух юм гэнэ, **яахав ийхэв** гэж элч давхиулж очиж хэлсэн. Тэгээд харин намайг очтол **яахав** орон гэр барьж өгөөд байзнаж бай, би очиж байж, үүлзаж байж болно гэсэн юм байна лээ. Тэгээд ноён хичнээн ч хоносон тэгээд ирээд энэ ламтай үүлзаад, танилцаад, учир зүйгээ ярьцгаасан юм байлгүй, тэгээд орон сууц барьж өгөхөөр болоод, энэ дуганыг бариулахаар яасан юм гэнэ лээ. Хоёр тангадтай гурвуулаа ирж байсан гэсэн байхаа. Тэгээд тангадууд нь сүрхий үлсууд байсан юм байгаа биз, тэд нар нь зааж зааварлаж, манай хүрээний хамаг мужаан сайчууд, уран зураачид цугаараа нийлж байгаад энэ дуганыг барьсан юм гэнэ лээ.

Тэгээд баруун тийш нь харуулж барь гэсэн, тэгэхээр яасан янзын лам бэ, манай дуганууд дандаа л урагшаа харж байдаг, тэгэхэд баруун тийш нь бариулах гээд байдаг, ноёнд айлтгасан юм гэнэ лээ. Ингээд байх юм нөгөө лам чинь, **яахав** гэсэн юм гэнэ лээ. За тэгвэл **яахав** би очоод **үүлзаадахъя** гэсэн. Тэгээд ноён ирээд үүлзсан энэ лам чинь та яагаад ингэж дуганаа баруун тийш нь харуулж барих гэж байгаа юм бэ? ямар учиртай юм бэ гэсэн чинь за **яахав** дээ үлдэх болов уу гэж бодсон юм. Тэгээд би баруун тийш нь бариулах гэсэн юм гэсэн юм гэнэ лээ. Тэгвэл за тэг тэг гэсэн юм гэнэ лээ. Тэгээд энэ дуганы чинь жинхэнэ ламын хурал хурдаг дуган биш байсан юм шүү дээ, хааяа нэг **сэнчин чиваа** хурдаг, доод өрөөнд нь лам өвөлд байдаг, дээд өрөөнд нь зунд морилдог тийм л байдаг байсан юм гэнэ лээ, энэ чинь хоёр давхар шүү дээ.

Манай дуганууд устаад, тэр үед дуган сүмийг устгахад энэ үлдсэн. Үлдэхдээ яасан бэ гэхээр **Хоржавын Чулуунбат** гээд манай нэг нэлээн бярттай, барилддаг ийм лам байсан юм. Тэр жингийн **нэгтгэлийг** чинь байгуулаад 10 хэдэн үлсууд жингийн **нэгтгэлийн** гишүүн болоод лам нараасаа залуухан жин аянд явдаг үлсууд. Тэгээд жингийн нэгтгэл байгуулаад тэгээд жингийн нэгтгэл энийг чинь тэр юунаас худалдаж авсан, тэр үед хямдхан даа. Жингийн нэгтгэл худалдаж аваад **складаа** хийгээд тэгээд үлдээсэн юм даа. Тэрнийг **склад** болгохын тулд засаг төрөөс тэгсэн юм байлгүй. Энэ их олон дуган, ном элдэв янзын зургийг арилга, хус гэсэн юм байна лээ. Энэ чинь хусаад арилахгүй. Тэгээд шохойдчихсон ийм байсан. Будган дээрээс нь шохойдсон.

Жингийн нэгтгэлийн **овтойхон** ч хүн байсан юм байна, энд тэнд аян юм хийдэг, барилддаг тийм л хүн байсан юм даа, тэр л аваад үлдсэн юм. Лам ч өөрөө ч тэгж ингэж үлдэхийг нь айлдаж байсан юм байлгүй.

Асуулт:-Дайчин вангийн хүрээний мал хуйгаа яаж малладаг байсан, жасын талаар та ярьж өгөх үү?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Жасын мал хандив, айлуудад тавьдаг байсан юм. Им тамгатай, тусгай, жасын сүрэг маллаач гээд тусгай **малчингууд** байсан. Энгийн хар улс байсан.

Асуулт:-Хичнээн тооны малтай байсан юм бол?

Хариулт:-Мэдэхгүй. Манай Цогчэн жас овоо малтай байсан юм гэнэ лээ.

Асуулт:-Дайчин вангийн хүрээ татвар төлдөг байсан уу?

Хариулт:-Мал хуй байтугай, хүн нэг бүрээс татвар авч байсан, **залуухнаас** нь цэргийн насны татвар, **ламханаас** нь ламын татвар гээд. Дээхнэ үеэс нь дээд толгой том толгой лам нарын татвар гээд татвар авч байсан юм. Тэгэхэд чинь мөнгө төгрөг ч ховор байлаа. 400 төгрөг, 200 төгрөгөөр татвар авч байхад их л юм шиг байсан даа. Сүүлд нь зарим нь 200 төгрөг, 400 төгрөг олж өгч чадахгүй байж байгаад татагдаад баригдаад явсан, зарим нь ч нэг юм тал тийшээ ах дүүгээ явуулж, мал хуйгаа зарж явж байж хагас хугас төлж л байсан юм даа.

Асуулт:-Жилдээ нэг удаа юу, сар болгон уу?

Хариулт:-Жилдээ нэг удаа, цэргийн **насныхад** бол нэг удаа, лам нар ч гэсэн нэг удаа. Нэг удаагийнхаа тэрний төлөхөд бэрхтэй байсан юм даа. Мөнгө төгрөг ховор.

Асуулт:-Дайчин вангийн хүрээний гол шүтээн нь ямар бурхан байсан юм бэ?

Хариулт:-Ванданхлам байсан. Чойр нь болохоор Ядам байсан .

Асуулт:-Энэтхэг, Төвдийн **дацангуудтай** холбоотой байсан уу? энд **Чойрын** ч юмуу, багш нар ном зааж байсан уу?

Хариулт:-Энэтхэг, Төвдөөс ирээд ном зааж байгаа гэсэн юм байхгүй, зүгээр төвдөд суралцаад ирсэн том том лам нар байсан л даа. Хамба нар. Бид нар тэр биш, энэ багш гэгцгээдэг л байсан. Би жижигхэн болоод тэр том том лам нараар ном заалгаж яваагүй. Зүгээр л шавь орж байсан.

Асуулт:-Тэр багш нар яаж ном зааж байсан?

Хариулт:-Зарим нь хавчиг үүрэг үүрээд явж байсан, зарим нь төгсөөд ирсэн л гэдэг юм.

Асуулт:-Та нэрийг нь санаж байна уу?

Хариулт:-Хоёр гурвыг мэднэ. Содов ламхай гэж лам байсан, Лүнгийн хамба багш гэж байсан, тэр их л эрдэмтэй, их номтой л хүн байсан, тэгээд наагуур нь лам нар байсан л даа.

Асуулт:-Содов лам гуай чинь сүүл рүүгээ суурь газар хийдэд байсан уу?

Хариулт:-Үгүй ээ. Энд байж байгаад явсан.

Асуулт:-Цуг ном үзэж байсан хүүхдүүдийнхээ тухай ярьж өгөхгүй юу? яаж ном уншиж байсан юм.

Хариулт:-Бид нар гэр гэрээрээ, одооныхтой адилхан сургууль шиг сурч байсан юм байгаагүй, гэр гэрээрээ дор **дорынхоо** багш нараас өглөө Цогчэндоо орж **ирчихээд**, Цогчэныхоо завсарлагаанд багшид самбартаа номоо бариад очдог, багш байж байдаг. Тэгээд багшид номоо урд өдрийнхөө номыг **шүүлгэчихээд**, тэгээд шинэ ном хэмжүүлээд авдаг. Тэгээд тэрнийгээ цээжилдэг. Оройд харин номоороо гороолдог гэрээ тойроод. Хашгираад, том дүүгаар. Тэгээд номоо цээжилж байсан.

Асуулт:-**Гэсгүй** нар явж шалгадаг байсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Хааяа нэг **гэсгүй** явна.

Асуулт:-**Гэсгүй** хэн гэдэг хүн байсан юм бэ?

Хариулт:-Олон **Гэсгүй** байсан.

Асуулт:-Энэ хийдээ 1990 онд дахин сэргэсэн тухай ярьж өгнө үү?

Хариулт:-Ардчилал үүсээд эрх чөлөөтэй болоход намын гишүүд намаа орхиж болох юм гэнэ, лам байсан улсууд ламаа хийж болох юм гэнэ, гээд иймэрхүү юм яриад бид нар энд хуучин лам байсан улсууд, 42-43 улсууд энд Баацагаанаас ч байсан, хотод байсан улсуудаас ч ирсэн, Баян-Овооноос ч байсан, Эрдэнэцогтоос байсан. Ингээд 42, 43 лам нар орсон доо.

Дандаа настай лам нар байсан. Хүүхдүүд нэг ч байгаагүй. **Маниусыг** зассанаас хойш л хүүхдүүд ганц хоёр хүүхдүүд орсон юм. Энд чинь байлгахгүй, ламын гэгээний Баянзүрхийн тэнд Монголын хуучин их түүхтэй хүрээ байсан. Их олон шавьтай байсан, тэнд лам нар хурна. Энд хуруулахгүй гэсэн. Төвөөс хүн ирсэн байсан, манай аймгийн соёлын **хэлтэсээс** хэдэн улсууд ирээд **маниусыг** тараах гээд тэгсэн л дээ. Та нар хурах л юм бол Баянзүрхэд оч гээд. Тэгээд үгүй гэж байгаад, эндхийн хамба байж байгаад өнгөрсөндөө Цэрэндорж гэж лам байсан. Тэр бид хоёрыг та хоёр л очиж явж шийд, бид нар явахгүй шүү, тийшээ явбал хурал хурахгүй, наадуул нь тэгж хэлээд тэгээд бид нар очиж тэр улсуудад учраа хэлсэн. Хэзээнээсээ түүхтэй, Вангийн хийд байсан юм, ийм 2, 3 хутагттай байсан, бид Ламын гэгээн рүү явахгүй. Вангийнхаа хурал хийнэ, ламын гэгээний шавь нараасаа л тэндээ хурал хуруулна гээд. Та нар чадах юмуу гэсэн. Чадна даа. Чадаж байсан юм, чадалгүй **яхав**. Дуган байна, ард түмний дэмжлэг тусламж байна, хандив байна, хөвөнтэй дээл, туургаа хүртэл авчраад суудал хийлгэж байна, цугаараа дор бүрдээ хөдөлж ард түмэн. Эндээ хийнэ. За тэгвэл **тэгдээ** гээд тэгээд зөвшөөрөл өгсөн.

Нөгөөдөр нь бид нар зуны эхэн сарын шинийн 8-нд хурлаа эхэлсэн. 1990 оны. Тэгээд хурлаа хийсэн юм даа.

Асуулт:-Шинээр үүсгэхэд голлож үүрэг гүйцэтгэсэн хүмүүсээс ярихгүй юу?

Хариулт:-Цугаараа л дор дороо хөдөлсөн дөө.

Асуулт:-Анхны хамба лам нь хэн гэдэг хүн байсан бэ?

Хариулт:-Готов гэж. Пунцагийн Готов гэж гэлэн хүн байсан. Гэхдээ одооны хамба нартай адилхан аж ахуй, мөнгөтэй хөөцөлдөөд байдаггүй, ном бурхныхаа талаар л яадаг байсан. **Гэсгүй** нь бол өндөр Дамдин гэж хүн байсан. Тэр нэлээн хэдэн жил энд **гэсгүй** хийсэн. Тэр Готовоос хойш чинь Цэрэндорж **боллуу** даа.

Асуулт:-Унзад нь хэн гэдэг хүн байсан бол, анхны?

Хариулт:-Бас Готов гэж хүн байсан. **Бядганы** Готов гэж хүн байсан. Тэр хийж байсан.

Асуулт:-Өдөр тутмын уншлагын талаар ярьж өгөхгүй, 90 оноос хойш ямар уншлага хийж байсан.

Хариулт:-Цогчэн уншлага, хуучин дээр үед сууж байсан Цогчэны уншлагыг л бид нар уншдаг байсан. Дараа нь **Ганданлхавжаа**, Гурван гүрэм, Цагаан шүхэрт, **Жамбалсанжид** өөр өөр нэмэлт хурлууд байсан л байх.

Асуулт:-Хуучны **Эрдэнэ вангийн** хүрээний лам нар зулын 25-ны өдрөөр ямархуу буюн үйлдэж, ямар хурал нь хурдаг байсан бэ?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Манайх зулын 25-нд **чогчид** хурж байдаг, **чогчидын** шавь нар гэж 10, 20-иод **чогчид** хурдаг лам нар байсан. Тэр бол **чогчидын** дуган гээд манай нэг жаахан дуган байсан. Тэндээ хурдаг байсан. Гурван жаяг нар дандаа тосон балин хийдэг байсан. Цагаан тосоор, өөхний тосоор. Усанд базаж байгаад өөхөн тосоор. 25-ны үдэш **чогчидын** дуганыхаа үүдэн дээр 25-ны балин гэж өндөр модонд босгоод хийчихсэн тийм л байсан юм даа.

Асуулт:-Хоёр нэртэй нэг дуган байсан гэсэн. **Оточийн** дуган, Дарь эхийн дуган гээд хоёр нэртэй нэг дуган байсан гэсэн.

Хариулт:-Оточ хурдаг байх үед **оточийг** нь хурчихна. Оточ хураад цэглэх юм бол Дарь эх хурдаг.

Асуулт:-Та тэр хуралд орж байсан уу?

Хариулт:-Оролгүй **яахав**. Хүүхэд байхаасаа. Хүүхдүүд чинь голдуу л Дарь эх уншиж сууна шүү дээ.

Асуулт:-Дарь эхийн нэг ая дагнаач.

Хариулт:-/Дарь эхийн маань уншив/ ийм аятай. Чойжид арай өөр аяар уншина.